



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/463

Улаанбаатар хот

Ойгоос хуш модны самар бэлтгэж
ашиглахыг бүсчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 13.1.5, 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум, Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын ойн сангаас хуш модны самрыг зөвхөн ахуйн зориулалтаар бэлтгэж, ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. Хуш модны самрыг тус тушаалын 1 дэх хэсэгт зааснаас бусад аймаг, сумдын сйн сангаас аль ч зориулалтаар бэлтгэж, ашиглах болон экспортлохыг 2020 оны 09 сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд хориглосугай.

3. Тушаалыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ойн бодлого зохицуулалтын газар /Б.Оюунсанаа/, Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар /Э.Сансарбаяр/, “Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ /Д.Мөнхбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Архангай, Баян-Өлгий, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Төв, Завхан, Хөвсгөл, Увс, Хэнтий аймгийн болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарт тус тус зөвлөсүгэй.

САЙД



Н.ЦЭРЭНБАТ

011187